



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/624

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын сувилагчдын баярыг тохиолдуулан ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээллийн ажилтан Р.Оюун, Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан С.Цагаанцоож, Үенч сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч А.Батцэцэг нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Р.Оюун, С.Цагаанцоож, А.Батцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ